

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны ...дугаар сарын
...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 7.1.5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журмыг хавсралтаар баталсугай.

2.Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг нарт, Улсын бүртгэлийн ерөнхий газар (Д.Дэлгэрсайхан), И-Монгол Академи Улсын төсөвт үйлдвэрийн газар (Б.Мягмарнаран)-т тус тус даалгасугай.

3.Хуримтлалын сангийн үйл ажиллагааг эрхлэн явуулах бүтэц орон тоо, техник тоног төхөөрөмж, программ хангамж болон бусад шаардлагатай төсвийн асуудлыг шийдвэрлүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа нарт үүрэг болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ИРГЭН БҮРД ХУРИМТЛАЛЫН НЭРИЙН ДАНС ҮҮСГЭХ, ХӨТЛӨХ, САНГААС ЗАРЦУУЛАЛТ ХИЙХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар Монгол Улсын иргэнд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас иргэдийн эрүүл мэнд, боловсрол, орон сууцанд дэмжлэг үзүүлэх, нөхцөлийг тодорхойлох, санхүүжилт олгох, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1.“хуримтлалын сан” гэж Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10.1.2-т заасны дагуу дэмжлэг үзүүлэх зориулалттай төрөлжсөн санг;

1.2.2.“хуримтлалын нэрийн данс” гэж Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 4.1.6-д заасан бүртгэлийг;

1.2.3.“орлого төвлөрүүлэгч хуулийн этгээд” гэж Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 4.1.5-д заасан хуулийг этгээдийг.

1.3.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Үндэсний баялгийн сангийн тухай хууль болон энэ журмын хэрэгжилтийг хариуцан ажиллах бүтцийн нэгжтэй байна.

Хоёр.Хуримтлалын нэрийн данс үүсгэх

2.1.Улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага иргэний улсын бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй Монгол Улсын иргэн бүрийн дараах мэдээллийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад нэг удаа хүргүүлнэ:

- 2.1.1.ургийн овог;
- 2.1.2.эцэг (эх)-ийн нэр;
- 2.1.3.өөрийн нэр;
- 2.1.4.дахин давтагдашгүй дугаар /регистрийн дугаар/;
- 2.1.5.хаягийн бүртгэлийн мэдээлэл.

2.2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 2.1-д заасны дагуу ирүүлсэн мэдээлэлд үндэслэн иргэн бүрийн нэр дээр хуримтлалын нэрийн данс үүсгэнэ.

2.3.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 2.2-т заасан хуримтлалын нэрийн дансны бүртгэлийг төрийн

үйлчилгээний цахим сан болох И-Монгол системд бүртгүүлэхээр И-Монгол Академи Улсын төсөвт үйлдвэрийн газарт хүргүүлнэ.

2.4.И-Монгол Академи Улсын төсөвт үйлдвэрийн газар иргэн бүрийн нэр дээр үүсгэсэн нэрийн дансны бүртгэлийг И-Монгол системд шинэ цэс үүсгэн байршуулж иргэн бүрд мэдээлэх боломжоор хангана.

2.5.Улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын мэдээллийн нэгдсэн санд шинээр төрсөн болон нас барсан, Монгол Улсын харьяатаас гарсан иргэний мэдээллийг сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон дараа сарын 5-ны дотор хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.6.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 2.5-д заасны дагуу ирүүлсэн мэдээлэлд үндэслэн хуримтлалын нэрийн данс бүхий иргэдийн бүртгэлд өөрчлөлт оруулж, энэ талаар И-Монгол Академи Улсын төсөвт үйлдвэрийн газарт мэдэгдэж, шаардлагатай өөрчлөлтийг И-Монгол системд бүртгүүлнэ.

2.7.Энэ журмын 2.5-д заасан мэдээллийг үндэслэн, нас барсан иргэний хуримтлалын нэрийн дансанд бүртгэлтэй хөрөнгийг Иргэний хууль тогтоомжийн дагуу өвлүүлснээр өвлөгчийн хүсэлтийн дагуу хуримтлалын нэрийн дансанд холбогдох бүртгэлийг хийнэ.

Гурав.Хуримтлалын нэрийн дансны бүртгэл хөтлөх

3.1.Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг Монголбанк дахь Төрийн сангийн дансанд байршуулна.

3.2.Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг дараах журмаар төвлөрүүлнэ:

3.2.1.орлого төвлөрүүлэгч хуулийн этгээд нь Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.2-т заасан эх үүсвэрийг төсвийн хуваарийн дагуу;

3.2.2.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10.3-т заасан хүү буюу өгөөжийг Засгийн газар, Монголбанкны хооронд байгуулсан гэрээнд заасан хуваарийн дагуу.

3.3.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 3.2-т заасны дагуу төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор иргэдийн хуримтлалын нэрийн данс бүрд ижил хувь хэмжээгээр хуваарилж бүртгэнэ.

3.4.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 3.3-т заасан бүртгэлийн мэдээллийг И-Монгол Академи Улсын төсөвт үйлдвэрийн газарт хүргүүлж, И-Монгол системд холбогдох бүртгэлийг хийлгэнэ.

3.5.И-Монгол Академи Улсын төсөвт үйлдвэрийн газар нь И-Монгол системээр дамжуулж дараах үйлчилгээг авах нөхцөлийг бүрдүүлнэ:

3.5.1.иргэний хуримтлалын нэрийн дансны бүртгэл үүсгэх, данс дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, зарцуулалтын түүхийг шалгах, зарцуулалт хийх хүсэлт гаргах, санал, хүсэлт өгөх;

3.5.2.хуримтлалын сангаас санхүүжилт авах боловсрол, эрүүл мэндийн байгууллага болон банк нь тухайн иргэний нэрийн дансны үлдэгдлийг шалгах.

Дөрөв.Хуримтлалын сангийн төсөв боловсруулж,
батлуулах, хуваарилах, хяналт тавих

4.1.Эрүүл мэнд, боловсрол, барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Эрдэнэс Монгол нэгдэл ХХК нь хуримтлалын сангийн дараа жилийн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарын саналыг Төсвийн тухай хуульд заасан хугацаанаас 10 хоногийн өмнө хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 4.1-д заасан саналыг нэгтгэн, төсвийн ангиллын дагуу төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарын саналыг боловсруулж, Төсвийн тухай хуульд заасан хугацаанд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.3.Эрүүл мэнд, боловсрол, барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Эрдэнэс Монгол нэгдэл ХХК нь хуримтлалын сангийн дараа жилийн төсвийн төслийн саналыг батлагдсан төсвийн хязгаарт багтаан боловсруулж жил бүрийн 07 дугаар сарын 20-ны дотор хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.4.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хуримтлалын сангийн төсвийн төслийг, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийн саналын хамт жил бүрийн 07 дугаар сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн аудитын байгууллага, Улсын Их Хуралд хүргүүлж, нийтэд ил тод мэдээлнэ.

4.5.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 3.5.1-д заасан, иргэдээс ирүүлсэн хүсэлтэд үндэслэн энэ журмын 4.4-т заасан саналыг боловсруулахад ашиглаж болно.

4.6.Хуримтлалын сангийн төсвийн орлого, зарлагын төрлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төсвийн хууль тогтоомжид нийцүүлэн батлуулна.

4.7.Батлагдсан жилийн төсвийн дагуу хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь эрүүл мэнд, боловсрол, барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад холбогдох санхүүжилтийг энэ журмын 4.4-т заасан хэмжээгээр шилжүүлнэ.

4.8.Эрүүл мэнд, боловсрол, барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 4.7-д заасан санхүүжилтийг энэ журамд заасан зориулалтын дагуу зарцуулах ба зарцуулалтын талаар сар бүрийн эхний 10 хоногт багтаан хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнаж мэдээлнэ.

4.9.Хуримтлалын сангаас санхүүжүүлэх зарцуулалтын төрөлд өөрчлөлт оруулах шаардлагатай бол холбогдох төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах замаар асуудлыг шийдвэрлэнэ.

4.10.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрүүл мэнд, боловсрол, барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хагас жилийн хуримтлалын сангийн төсвийн гүйцэтгэлийг 7 дугаар сарын 20-ны дотор, жилийн төсвийн гүйцэтгэлийг дараа оны 1 дүгээр сард багтаан дүгнэж, тооцоо нийлж, баталгаажуулна.

4.11.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жилийн төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд заасан цаглаврын дагуу боловсруулж, тайлагнана.

Тав.Хуримтлалын сангийн хөрөнгийн зарцуулалт,
ерөнхий нөхцөл, шалгуур үзүүлэлт

5.1.Хуримтлалын нэрийн данстай иргэн нь хуримтлалын сангаас эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ болон орон сууц худалдан авахад дэмжлэг авах бол энэ журмын 3.5.1-д заасны дагуу И-Монгол систем дэх бүртгэлээр дамжуулан гаргах тохиолдолд цахимаар, эсхүл цаасаар холбогдох хүсэлтийг энэ журмын нэгдүгээр хавсралтаар баталсан маягтын дагуу гаргана. Цаасаар хүсэлт гаргах бол харьяа нутаг дэвсгэрийн нийгмийн даатгалын газар, эсхүл нийгмийн даатгалын ажилтанд өгнө.

5.2.Хуримтлалын сангаас хуримтлалын нэрийн данстай иргэн нь өөрийн асрамжид байдаг Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4-т заасан гэр бүлийн гишүүнд зориулж Монгол Улсын нутаг дэвсгэрт үзүүлэх эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ болон орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлж болно.

5.3.Дараах нөхцөл, шалгуурыг хангасан тохиолдолд хуримтлалын нэрийн данстай иргэн Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7.1.2-т заасны дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх хэсгээс бусад даатгуулагчийн төлөх төлбөрт хуримтлалын сангаас хөрөнгө зарцуулж болно:

5.3.1.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь Монгол Улсын холбогдох төрийн байгууллагаас магадлан итгэмжлэгдсэн байх;

5.3.2.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь холбогдох төлбөрийн нэхэмжлэхийг ирүүлсэн байх.

5.4.Дараах нөхцөл, шалгуурыг хангасан тохиолдолд хуримтлалын нэрийн данстай иргэн боловсролын үйлчилгээнд хуримтлалын сангаас хөрөнгө зарцуулж болно:

5.4.1.магадлан итгэмжлэгдсэн, зөвшөөрөл бүхий дээд боловсролын сургалтын байгууллага байх;

5.4.2.дээд боловсролын сургалтын байгууллага нь холбогдох төлбөрийн нэхэмжлэхийг ирүүлсэн байх.

5.5.Энэ журмын дагуу хуримтлалын сангаас урьдчилгаа төлбөрийн санхүүжилтэд дэмжлэг үзүүлэх орон сууцны ипотекийн зээл нь дараах нөхцлийг хангасан байна:

5.5.1.Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/295 дугаар тушаалын хавсралтаар баталсан Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам (цаашид “Ипотекийн зээлийн журам” гэх)-ын нөхцөл, шалгуур үзүүлэлтийг хангасан байх;

5.5.2.банкны санхүүжилтийн эх үүсвэрээр ипотекийн зээлийн орон сууц худалдан авах бол тухайн банкны зээлийн ерөнхий нөхцөл, шалгуур үзүүлэлтийг хангасан байх;

5.5.3.анх удаа орон сууц худалдан авч байх;

5.5.4.өөрийн өмчийн орон сууцгүй байх /гэр бүлийн гишүүний нэр дээрх орон сууцанд хамтран эзэмшигчээр бүртгэгдсэн байж болно/.

5.6.Энэ журмын дагуу хуримтлалын сангийн санхүүжилтээр боловсрол, эрүүл мэнд, орон сууцыг иргэнд худалдах, санхүүжүүлэх байгууллага нь иргэний хуримтлалын нэрийн дансны үлдэгдэл шалгах эрхтэй байна.

5.7.Хуримтлалын сангаас орон сууцны ипотекийн зээл олгоход шаардлагатай эх үүсвэрийг Монголбанкаар дамжуулан санхүүжүүлж болно.

Зургаа.Эрүүл мэндийн үйлчилгээний санхүүжилт авах хүсэлт гаргах, санхүүжилт олгох

6.1.Энэ журмын 5.3-т заасан шалгуур хангасан иргэн нь эрүүл мэндийн үйлчилгээний санхүүжилт шийдвэрлүүлэх хүсэлтийг хуримтлалын сан болон холбогдох эрүүл мэндийн байгууллагад энэ журмын 5.1-д заасны дагуу гаргана.

6.2.Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага үйлчилгээ авсан иргэний мэдээлэл, төлбөрийн талаар мэдээллийг тухай бүр эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэнэ.

6.3.Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь тухайн сард үзүүлсэн үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэхийг дараа сарын 5-ны өдрийн дотор эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар хүргүүлнэ.

6.4.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь эрүүл мэндийн үйлчилгээний санхүүжилтийг иргэний хүсэлт, эрүүл мэндийн тусламж, үзүүлэгч байгууллагын нэхэмжлэхийг хүлээн авч, шалган ажлын 5 өдөрт багтаан холбогдох санхүүжилтийг шилжүүлнэ.

6.5.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага хооронд энэхүү төлбөр тооцоотой холбоотой тооцоог сар бүр хийж баталгаажуулна.

6.6.Эрүүл мэндийн байгууллага нь хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг шалгах техник, технологийн бэлэн байдлыг бүрдүүлсэн байна.

6.7.Энэ журамд заасны дагуу эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сар тутам хуримтлалын сангийн эх үүсвэрээр санхүүжилт олгосон талаарх тайлан мэдээллийг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа сарын 5-ны дотор хүргүүлж байна.

Долоо.Боловсролын үйлчилгээний санхүүжилт авах
хүсэлт гаргах, санхүүжилт олгох

7.1.Энэ журмын 5.4-т заасан шалгуур хангасан иргэн нь жил бүрийн 1 дүгээр сарын 15, 8 дугаар сарын 10-ны дотор боловсролын үйлчилгээний санхүүжилт шийдвэрлүүлэх хүсэлтийг энэ журмын 5.1-д заасны дагуу хуримтлалын сан болон холбогдох дээд боловсролын сургалтын байгууллагад гаргана.

7.2.Дээд боловсролын сургалтын байгууллага нь 2 дугаар сарын 10, 8 дугаар сарын 25-ны дотор хуримтлалын сангаас санхүүжилт шийдвэрлэх иргэний хүсэлт, төлбөрийн нэхэмжлэх, суралцагчийн мэдээллийг нэгтгэн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар хүргүүлнэ.

7.3.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 7.2-т заасан төлбөрийн нэхэмжлэхийг хүлээн авч, шалган 2 дугаар сарын 20, 9 дүгээр сарын 10-ны дотор холбогдох санхүүжилтийг шилжүүлнэ.

7.4.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад болон дээд боловсролын сургалтын байгууллага хооронд энэхүү төлбөр тооцоотой холбоотой тооцоог тухай бүр хийж баталгаажуулна.

7.5.Энэ журамд заасны дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хуримтлалын сангийн эх үүсвэрээр санхүүжилт олгосон талаарх тайлан мэдээллийг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 03 дугаар сарын 10, 9 дүгээр сарын 20-ны дотор хүргүүлнэ.

7.6. Дээд боловсролын сургалтын байгууллага нь хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг шалгах техник, технологийн бэлэн байдлыг бүрдүүлсэн байна.

Найм.Орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилт олгох

8.1.Ипотекийн зээлийн журмын 3.3-т заасны дагуу банк зээлийн шийдвэр гаргасан бол энэ журмын 5.1-д заасны дагуу урьдчилгаа төлбөр олгуулах хүсэлтийг хуримтлалын сан, барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

8.2.Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага банкны шийдвэр гарсан эсэхийг шалган, хүсэлт хүлээн авснаас хойш ажлын 3 өдөрт багтаан ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрт санхүүжүүлэх боломжтой хөрөнгийг банканд шилжүүлнэ.

8.3.Энэ журмын 5.5-д заасан баримт бичгийг банк хуурамчаар үйлдсэн нь тогтоогдвол урьдчилгаа төлбөрийн санхүүжилт олгохгүй бөгөөд үүнээс үүсэх аливаа эрсдэлийг буруутай этгээд хариуцна.

8.4.Банк нь энэ журам болон Ипотекийн зээлийн журамд заасан шаардлагад нийцүүлэн зээл олгох шийдвэр гаргаснаар урьдчилгаа төлбөрийг, зээлийн хамт, тухайн банканд дахь орон сууц борлуулагчийн нэр дээрх харилцах дансаар дамжуулан олгоно.

8.5.Хуримтлалын сангаас санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх, иргэний худалдан авах орон сууцны урьдчилгаа төлбөрийн дээд хэмжээ нь 65 сая төгрөгөөс хэтрэхгүй байна.

8.6.Энэ журамд заасны дагуу барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хуримтлалын сангийн эх үүсвэрээр санхүүжилт олгосон талаарх сарын бүрийн тайлан мэдээллийг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа сарын 5-ны дотор хүргүүлнэ.

8.7.Энэ журмын 5.7-д заасны дагуу санхүүжилт олгох тохиолдолд Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хангасан байдал, ипотекийн зээлийн багцыг харгалзан, арилжааны банкнаас хуримтлалын сан, Монголбанканд гаргасан хүсэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.

Ес.Мэдээ, тайлан

9.1.Хуримтлалын нэрийн дансны бүртгэлд хуримтлалын сангаас төвлөрүүлсэн хөрөнгийн эх үүсвэр, өгөөж, хуримтлалын сангаас эрүүл мэнд, боловсрол, орон сууцны санхүүжилтэд зарцуулсан мөнгөн дүн, үлдэгдэл зэргийг энэ журмын хоёрдугаар хавсралтаар баталсан маягтын дагуу тодорхой харуулж, тухай бүр бүртгэлийг хөтлөх ба энэхүү мэдээллийг иргэд өөрийн бүртгэлээр дамжуулан шалгахад нээлттэй ил тод байна.

9.2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийн зарцуулалтын талаарх тайлан

мэдээллийг /эрүүл мэнд, боловсрол, барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зарцуулсан үйлчилгээ тус бүрээр/ хуримтлалын нэрийн данс дахь мөнгөн хөрөнгө, зарцуулалт, үлдэгдлийг тухай бүр бүртгэнэ.

9.3.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь эрүүл мэнд, боловсрол, барилга хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай энэ журмын 4.10-т заасны дагуу жил бүр тооцоо нийлж баталгаажуулна..

9.4.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хуримтлалын сангийн хагас, бүтэн жилийн санхүү, үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглаврын дагуу гаргаж, дээд шатны байгууллагад хүргүүлж, олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

Арав. Хяналт, хариуцлага

10.1.Иргэн хуримтлалын нэрийн дансны хөрөнгө, өгөөж, зарцуулалтыг тухай бүр хянаана.

10.2.Иргэдэд олгох эрүүл мэнд, боловсрол, орон сууцны дэмжлэг олгох үйл ажиллагаа нь энэ журам болон холбогдох бусад журмын дагуу хэрэгжиж байгаа эсэхэд хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсрол, барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус хяналт тавина.

10.3.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын
нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас
зарцуулалт хийх журмын нэгдүгээр хавсралт

ХУРИМТЛАЛЫН НЭРИЙН ДАНСНААС ЗАРЦУУЛАЛТ ХИЙХ
ХҮСЭЛТ ГАРГАХ МАЯГТЫН ЗАГВАР

Хүсэлт гаргагчийн мэдээлэл:

1. Ургийн овог:
2. Овог:
3. Нэр:
4. Регистрийн дугаар:.....
5. Оршин суугаа хаяг:.....
6. Хуримтлалын нэрийн дансны дугаар:
7. Зарцуулах зориулалт: *тохирох хэсгийг чагтлах*

Эрүүл мэнд

Боловсрол

Орон сууц

8. Хэнд зориулж зарцуулах: *тохирох хэсгийг чагтлах*

Өөртөө:

Гэр бүлийн гишүүнд зориулж:

9. Үйлчилгээ авах байгууллагын нэр, хаяг:
10. Дэмжлэг авах мөнгөн дүнгийн хэмжээ:

Гарын үсэг:

Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын
нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт
хийх журмын хоёрдугаар хавсралт

ХУРИМТЛАЛЫН НЭРИЙН ДАНС ДАХЬ МӨНГӨН ХӨРӨНГИЙГ
ИРГЭНД МЭДЭЭЛЭХ ХУУДАС

..... оны сарын өдөр

Иргэний:

Эцэг/эхийн нэр:.....

Нэр:.....

Дахин давтагдашгүй дугаар:

..... оны Хуримтлалын нэрийн дансны эхний үлдэгдэл.....

				/төгрөгөөр/
Сар	Ногдол ашгаас хуваарилсан хөрөнгө	Хөрөнгө оруулалтын өгөөжийн дүн	Зарлага	Нийт мөнгөн хөрөнгө
	1	2	3	4
1				
Дүн				

..... оны Хуримтлалын нэрийн дансны эцсийн үлдэгдэл:

.....